



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2023 оны 01 дугаар сарын 24

№ 06/04

Улаанбаатар хот

АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.11, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн, аймгийн "Хүүхдийн эрхийн Хууль зүйн Хорооноос гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үзүүлж буй үйл ажиллагаа", "Төрийн захиргааны байгууллагуудад Ахмадын сан байгуулсан эсэх", "Төрийн байгууллагуудын барилга байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй эсэх, "СОС" хүүхдийн асрамжийн төв, "Нарны хүүхдүүд" асрамжийн төв, " " политехник коллежийн дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд 2022 оны 10 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтыг дээрх байгууллагуудын удирдлага, алба хаагч, ажилтнуудтай ярилцлага хийх, нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, дуу-дүрсээр баримтжуулах, гудамж талбай, байгууллагын орчин нөхцөлд ажиглалт хийх, оюутны дотуур байр болон асрамжийн төвийн байранд амьдарч байгаа хүүхдүүдийн төлөөлөлтэй ярилцлага хийх, судалгааг гаргуулан авах, холбогдох баримт бичиг, тайланд дүн шинжилгээ хийх аргачлалаар явуулсан бөгөөд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

Нэг.Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар:

Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 10 арга хэмжээ, 36 үйл ажиллагаатайгаар, 34,000,000 (гучин дөрвөн сая) төгрөгийн санхүүжилттэй хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь сайшаалтай боловч тухайн оны үйл ажиллагааны тайланд 10,000,000 (арван сая) төгрөгийг хуваарилан, 3 дугаар улирлын байдлаар 9,070,000 (есөн сая далан мянган) төгрөгийг хүүхэд хамгааллын зардал, орон нутгийн төсвөөс зарцуулсан байгаа нь хороо хүүхэд хамгааллын зардалд тусгасан санхүүжилтийг бүрэн дүүрэн зарцуулаагүйг харуулж байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2022 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийхэд тус хороо нь Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоотой хамтран "Банхар арт терапи" төслийг 7 сая төгрөгийн төсөвтэйгөөр үе тэнгийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхэд хүүхэдтэйгээ эерэгээр харилцах үе тэнгийн сурагч, монёруудыг бэлтгэх сургалтыг зохион байгуулж 26 сургуулийн 260 хүүхдийг сургагч багшаар бэлтгэсэн байна. Хороо нь хамтарсан багтай хамтран "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг" хэлэлцүүлгийг зохион байгуулж, эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, багийн хэсгийн байцаагч нарт "Хохирогч төвтэй хандлага" сургалтыг зохион байгуулж идэвх санаачилгатай манлайлан ажиллажээ.

Хорооноос гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байдлыг авч үзвэл 2021 онд 115, 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар 108 хүүхдэд холбогдох үйлчилгээг үзүүлжээ. 2021 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд 47, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 17, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 9, сэжигтэн 38 хүүхдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Мөн 2022 оны эхний 10 сарын байдлаар гэмт хэргийн улмаас хохирсон 37, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 4, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 2, сэжигтнээр тооцогдсон 4, гэрч 63 хүүхдэд туслалцаа үзүүлсэн нь нийт гэмт хэрэгт холбогдож, хохирсон хүүхдийн 41.6-56.4 хувьд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс дүгнэхэд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд бүрд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хангалттай хүрч ажиллаагүй байна.

Тус Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.4 дэх заалт “энэ журамд заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг бүрдүүлэх, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”, 4.4.6 дахь заалт “сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хууль зөрчсөн хүүхдэд зөв хүмүүжил олгох, хорт зуршлаас ангижрахад чиглэгдсэн боловсрол, мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаан, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах төлөвлөгөөг хууль зүйн хорооны хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэнэ” заалтыг хэрэгжилтийг хангаагүй байна.

Түүнчлэн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний ажлын албаны хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг бүртгэх, мэдээлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож түүнийг арилгах, дахин гаргахгүй байх арга хэмжээг авах талаар орон нутаг дахь төрийн захиргааны болон хуулийн байгууллагуудтай хамтарч ажиллах талаар тусгагдаагүй байгаа нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.10 дахь заалт “Ажлын алба нь хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг бүртгэх, мэдээлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож түүнийг арилгах, дахин гаргахгүй байх арга хэмжээг авах талаар орон нутаг дахь төрийн захиргааны болон хуулийн байгууллагуудтай хамтарч ажиллана” гэсэн зохицуулалтыг хангаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт “... хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт “төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах”, 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт “Хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах...эрхтэй”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй”, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт “хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах” гэж тус тус заасан.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-д хорооны үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтыг тусгасан.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд хийсэн хяналт шалгалтын талаар:

аймгийн Статистикийн хэлтсийн мэдээгээр 2022 оны 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 4714 иргэн бүртгэлтэй байгаагаас 438 хүүхэд байна. Тэдгээрийг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл, харааны бэрхшээлтэй 14.8 хувь, тулгуур эрхтэний бэрхшээл 9.8 хувь, хэл ярианы бэрхшээл 8.3 хувь, сонсголын бэрхшээлтэй 12.6 хувь, сэтгэцийн хувьд бэрхшээлтэй 10.9 хувь, бусад 23.5 хувь байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх байдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээгавна" гэж, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Орон сууц, олон нийтийн барилга, байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна", Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт "Барилгын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх зарчмыг баримтална" гэж тус тус заасан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд тэгш хамруулах шаардлагыг MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлагыг тооцсон орон зайн, орчин, Үндсэн шаардлага", MNS 6056:2009 "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар", MNS 5682:2006 "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зам, Техникийн шаардлага"-д тус тус заажээ.

Комисс аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд дүн шинжилгээ, хяналт шалгалт хийхэд Аймгийн Засаг даргын тамгын газар (Нутгийн удирдлагын ордон), Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Прокурорын газар, Сум дундын Шүүхийн Тамгын газар, Давж заалдах шатны шүүхийн Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар зэрэг 11 байгууллага хамрагдсан. Үүнээс налуу замыг стандартад нийцүүлсэн 2 байгууллага, стандартын бус налуу замтай 9 байгууллага, налуу зам нь бариултай 8 байгууллага, бариул хийгдээгүй 3 байгууллага, хүлээлгийн сандалтай 11 байгууллага, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээллийг зайлшгүй хүлээн авах өрөө тасалгаатай 2 байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан таних тэмдэг, тэмдэглэгээтэй 3 байгууллага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөндөө зориулалтын бариултай 2 байгууллага, байгууллагын доторх өрөө тасалгааны хаалга стандартын буюу 85-аас дээш см

хаалгатай 9 байгууллага байна. Хаалганы босго 2.5 см-тай байгууллага түүнээс дээш хэмжээтэй 8 байгууллага, байгууллагын гадаа хаалганы өргөн 85-аас дээш см хэмжээтэй 8 байгууллага байгаа нь тус аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломж, нөхцөлийг хангалттай бүрдүүлээгүй байна гэж үзсэн.

Харин Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс нь сонсголын бэрхшээлтэй иргэнд үйлчлэх цахим хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ нэвтрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх ариун цэврийн өрөө, хүлээлгийн сандал, тэмдэг тэмдэглэлээ байрлуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, хүний эрхэд суурилсан хандлагаар төрийн үйлчилгээ үзүүлэх, хүртээмжтэй орчныг бий болгож манлайлан ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Гурав.Ахмадын сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар: [redacted] аймгийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 18,902 ахмад настан бүртгэлтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3-т “аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам”-д тус тус заасан.

[redacted] аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс авсан мэдээллээр аймгийн хэмжээнд Шүүхийн шинжилгээний алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 445 дугаар нээлттэй хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 435 дугаар хаалттай хорих анги, Цагдаагийн газрын ахмадын сан, Татварын хэлтэс зэрэг зургаан байгууллага “Ахмадын сан”-гийн данс нээсэн байна. Шалгалтад хамрагдсан [redacted] аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Соёл, урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг таван байгууллага “Ахмадын сан” байгуулаагүй байгаа нь ахмад настны хөгжих, хамгаалуулах эрх хангагдаагүй байна гэж үзсэн.

Дөрөв. “Нарны хүүхдүүд” асрамжийн төвийн байрны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар:

Нарны хүүхдүүд асрамжийн төв 2002 онд ашиглалтад орсон 483.36 м.кв талбай бүхий 5 барилгад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ оны 10 дугаар сарын байдлаар 40 хүүхэд амьдарч байна.

Комиссын шалгалтын явцад тус төвийн хүүхдүүд 2003 оноос хойш Япон Улсад 22 удаа урлагийн тоглолт зохион байгуулж, тоглолтоос олсон орлогоор өөрсдийн үйл ажиллагааны урсгал зардал, ахуй нөхцөл, сургалтын орчинг сайжруулах, оюутан суралцагчдын төлбөр төлөхөд шаардлагатай хөрөнгө оруулалт, зардлыг санхүүжүүлж иржээ. Тухайлбал, тус төвийн хотхонд 2005 онд Урлагийн сургууль, 2006 онд охидын төв, хүндэтгэлийн өргөө, авто угаалгын газар гэх нийт 6 объект барьсан, 2022 онд охид хөвгүүдийн тасгийн засвар үйлчилгээ хийсэн байна.

Асрамжийн төвийн хүүхдүүд ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамрагддаг, хичээлийн бус цагаар тус төвийн уран нугаралт, дуу хөгжим, бүжгийн дугуйланд долоо

хоногт 2-3 удаагийн давтамжтай хамрагдаж бэлтгэл сургуулилт хийдэг нөхцөл байдал тогтоогдсон. Хүүхдүүдтэй хийсэн ярилцлагаар өөрсдийн хүсэл сонирхлоор дугуйланд хамрагддаг гэж байгаа ч хүүхдийн эрхийн зөрчил, албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн холбогдох байгууллагаас тогтмол хяналт тавихын зэрэгцээ дэмжиж байх нь зүйтэй.

Шалгалтын явцад төрөөс хүүхдэд олгож байгаа мөнгөн тэтгэмжийг хүүхэд тус бүрийн нэр дээр нээсэн “Худалдаа хөгжлийн банк”-ны хадгаламжийн дансанд төвлөрүүлж, хүүхэд зөвшөөрвөл зарлагын гүйлгээ хийдэг, төрөөс асрамж, халамжийн төвд олгодог хоолны нэмэлт болон хувцас, ахуйн хэрэглээний санхүүжилт холбогдох журмын дагуу олгогддог нь тогтоогдсон. Харин Япон Улс болон дотоодод зохион байгуулдаг урлагийн тоглолтод оролцсон хүүхдүүдэд олсон орлогоос ямар нэг урамшуулал, цалин хөлс олгодоггүй байдал тогтоогдсон, тэдний оролцоотойгоор олсон орлогоос Аймгийн хэмжээнд бүртгэлтэй зорилтод бүлгийн 100 хүүхдэд хичээлийн хэрэгслийн санхүүжилтэд сайн дураар хандивласан, санхүүжилтийг аймгийн холбогдох албан тушаалтнууд хүлээн зөвшөөрч зарцуулсан нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан хүүхдийн эрхийг зөрчиж буй хэлбэр юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дахь хэсэгт “Хүүхдийн талаар аливаа үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргахдаа юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна”, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэгт “хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т “хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д “хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг дэмжих”, Хөдөлмөрийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.2 дахь хэсэгт “Насанд хүрээгүй хүний оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглоно”, мөн зүйлийн 142.5 дахь хэсэгт “15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн бичгээр гаргасан зөвшөөрөл, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг үндэслэн хүүхдийн эрхийн улсын байцаагч тухай бүр зөвшөөрөл олгосон бол хөдөлмөр эрхлүүлж болно” гэж тус тус заасан.

Тав.Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн дотуур байранд хийсэн хяналт шалгалтын талаар:

“Оюуны ирээдүй цогцолбор” сургуулийн дотуур байр нь тус сургуулийн хичээлийн байрны 2 давхарт байрладаг бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд 2-12 дугаар ангийн 81 сурагч амьдарч байна.

Тус сургуулийн дотуур байрны нөхцөл байдалтай танилцахад сурагчдын өрөө, хүүхэд хөгжлийн өрөө, ариун цэврийн өрөөний дээврээс ус нэвчсэн, зарим өрөөний хананд хөгц мөөгөнцөр үүссэн, хаалга бариул байхгүй, сурагчдын ор нь хуучирч, эдэлгээ муудан хүүхэд гэмтэж бэртэх эрсдэл үүссэн, цахилгааны утас ил задгай, өрөө тасалгааны агааржуулалт муу, дотуур байрны өрөө хоорондын сул хонгил хэсэгт байрлах аврах шатны хаалгыг модон хаалтаар хааж бэхэлсэн, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө тус бүрд 6 угаалтуур, суултуур 4, хөл угаах угаалтуур 9, сантехникийн эвдрэлтэй гэх шалтгаанаар 4 нь ашиглагдаагүй, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн бие засах өрөөний шаазан суултуур нь хүйтнээс хамгаалсан нэмэлт суултуургүй, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө, шүршүүр байхгүй,

дотуур байранд ариутгал, халдваргүйжүүлэлтийг цаг тухайд хийдэггүй зэрэг нөхцөл байдал тогтоогдсон нь сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээнд тавигдах MNS6781:2019 стандартын холбогдох шаардлагуудыг хангаагүй байна.

Дотуур байранд амьдарч байгаа сурагчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагад "...хоолондоо цаддаггүй өлсдөг, өдөрт 3 удаа хоол иддэг, хоол нэмүүлж идэхэд дургүйцдэг" талаар онцлон хэлж байлаа. Дотуур байрны 09 дүгээр сарын хоолны бүртгэлтэй танилцахад өглөөний цай, өдрийн хоол, оройн хоол өгч байсан нь дээр дурдсан стандартад заасан "...Хүүхдийн хоол бэлтгэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олон байлгаж, өдөр бүр 5 удаа (өглөө, бага үд, өдөр, их үд, орой) хоолоор үйлчилнэ" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Дотуур байрны дотоод журмыг захирал [redacted] баталсан байх боловч батлагдсан он, сар, өдөр тодорхойгүй, уг журамд дотуур байрын зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, жижүүр эмч, тогтооч нарын хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн хувиар, суралцагчийн хувийн нууцийг хамгаалах талаарх зохицуулалтуудыг тодорхой тусгаагүй байна. Түүнчлэн Дотуур байранд хийж гүйцэтгэх эрүүл мэндийн ажлын төлөвлөгөө баталсан байх боловч он, сар, өдөр байхгүй, ариутгал 14 хоногт 1 удаа хийлгэх, ариун цэврийн өрөөний ахуйн цэвэрлэгээ, ариутгалын бодис хийх зөвлөмж, халдваргүйжүүлэлт хийсэн бүртгэл байхгүй байлаа.

Сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээнд тавигдах MNS6781:2019 стандартын 8 дугаар зүйлийн 8.1-т "Дотуур байрын барилгыг жилд нэг удаа хөгц, мөөгөнцөртсөн хэсгийг цэвэрлэж ариутгах, будаж шохойдох зэргээр урсгал засвар хийнэ", мөн зүйлийн 8.2-т "Улирал тутам хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлт, ариутгалыг гэрээний үндсэн дээр, шаардлагатай үед хуваарь харгалзахгүйгээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ", мөн зүйлийн 8.4-т "Сургуулийн эмч дотуур байрын их цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд хэрэглэх бодис, хийх арга зөвлөмжөөр хангаж, хуваарийг сургуулийн захирлаар батлуулан хэрэгжүүлж, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийсэн тухай бүртгэл хөтөлнө" гэж тус тус заасан байх тул стандартын шаардлагад нийцээгүй байна.

Дотуур байрны багш, ажилчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагад "...манай дотуур байр 3 багштай, бид 8/16 цагийн ээлжээр ажилладаг, шөнийн ээлжийн нэмэгдэл цалин хөлс өгдөггүй, шөнийн ээлжийн нэмэгдлээ авах талаар сургуулийн захиргаанд хэлэхээр хүүхдийн тоо хүрэхгүй байна гэж хэлдэг, мөн сургуулийн дотуур байр байрлах 2 давхарт жижүүр байхгүй учраас бид байрны багшийн ажлаас гадна жижүүрийн ажил давхар хийдэг, сүүлийн 2 жил 8/16 цагаар ээлжлэн давхар жижүүрийн ажил хийдэг" талаар дурдаж байсан. Дотуур байр хариуцсан 3 багшид илүү цаг, шөнийн цагаар ажиллуулсан нэмэгдэл хөлсийг бодож олгохгүй байгаа нь холбогдох хууль, стандартыг зөрчиж байна.

Түүнчлэн Сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээнд тавигдах MNS6781:2019 стандартын 7 дугаар зүйлийн 7.9-т "дотуур байр бүрд 4 ээлжийн жижүүр ажиллана. Жижүүр хүүхдийг асран хамгаалах, хөгжүүлэхэд эцэг эх, багш, сургуультай хамтран ажиллана", Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.3 дахь заалт "Ажил олгогч ажилтантай тохиролцсоны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол ээлжийн ажлын цагийн үргэлжлэлийг дөрвөөс илүүгүй цагаар уртасгасан зохион байгуулж болно. Энэ тохиолдолд ажилтан долоо хоногт 40 цагаас илүү ажилласан бол түүнд илүү ажилласан цагийн хөлсийг энэ хуулийн 109.1 дэх заалтад заасны дагуу нэмж олгоно", мөн зүйлийн 109.3 дахь хэсэгт "Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин, хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно" гэж тус тус заасныг зөрчиж байна.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцын 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн b "...дунд боловсролын олон хэлбэр, түүний дотор ерөнхий болон мэргэжлийн боловсролыг хүүхэд бүрд хүртээмжтэй болгох, хөгжүүлэх, шаардлагатай тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх буюу үнэ төлбөргүй боловсрол олгох", мөн зүйлийн 2 дах хэсэгт "Оролцогч улсууд сургуулийн дэг журмыг дэмжих үүднээс хүүхдийн нэр төрд хүндэтгэлтэйгээр хандуулах бүхий л арга хэмжээг энэхүү Конвенцид нийцүүлэн авна", Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-т "... хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах" гэж тус тус заасан.

Мөн сурагчдын дотуур байрны үйл ажиллагаа, орчин нөхцөл, хоолны илчлэг, амьдрах болон ариун цэврийн өрөө, ариутгал, цэвэрлэгээ, галын аюулгүй байдал, соёл хүмүүжлийн арга хэмжээнд баримтлах шаардлагыг Монгол Улсын стандарт MNS 6781:2019 "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ, Ерөнхий шаардлага" стандарт, MNS 6782:2019 "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандарт", MNS 6890:2020 "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага"-д тус тус заажээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дугаар зүйлийн 7 дахь заалт "Монгол Улсын Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах...", Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт "Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцна" гэж заасныг тус тус удирдлага болгон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу дараах Шаардлагыг хүргүүлж байна.

Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны чиглэлээр

1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу явуулах, Хорооны дарга, гишүүдийн манлайллыг идэвхжүүлэх, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэх;
2. Ажлын алба нь хууль зөрчсөн хүүхдийн эрүү, зөрчлийн хэрэг, хувийн мэдээлэл, Хууль зүйн хорооноос үзүүлсэн үйлчилгээг агуулсан хувийн хэргийг хүүхэд бүрд нээж ажиллах, үйлчилгээ үзүүлж дууссаны дараа хорооны бүртгэл мэдээллийн санд шаардлагатай мэдээллийг оруулах, хувийн хэргээс төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцад хамаарахгүй баримт мэдээллийг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчид хүлээлгэн өгөх горимыг тогтоох;
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ын 4.4.4, 4.4.6, 5.10 дахь заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих;

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр

1. Аймгийн хэмжээнд нийтийн тээвэр, албан газар, олон нийтийн үйлчилгээний газар, орон сууц, гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон нийтийн газарт хөгжлийн

- бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандарт мөрдөгдөж байгаа эсэхэд үзлэг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах, хүрэлцээтэй байх орчин нөхцөл бүрдүүлээгүй аж ахуй нэгж байгууллагын барилга байгууламжийг холбогдох стандартад нийцүүлэх, цаашид стандартад нийцээгүй барилга байгууламж, зам талбайг хүлээн авч, ашиглалтад оруулахгүй байх шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтан, аж ахуй нэгж, олон нийтэд танилцуулж, хэрэгжилтийг хангуулах;
 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах.

Ахмад настны эрхийн чиглэлээр

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам"-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагуудад ахмадын сан байгуулах арга хэмжээ авч, зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

"Нарны хүүхдүүд" асрамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн эрхийг хангах чиглэлээр

1. Урлагийн тоглолт үзүүлбэрт оролцсон болон бусад байдлаар хөдөлмөр эрхэлсэн хүүхдэд урамшуулал олгохгүй байгаа явдлыг таслан зогсоож, тоглолтын үзүүлбэрээс олсон урамшууллын зохих хувийг тухайн хүүхдийн нэрийн дансанд олгох арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих;
2. "Нарны хүүхдүүд" асрамжийн төвийн байранд урсгал засвар хийх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хичээлийн хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангах, төвийн байрны цэвэр, бохир ус, цахилгаан, дулааны төлбөрт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах;
3. Хүүхдийг урлаг, спортын үзүүлбэрт оролцуулахаар бэлтгэж буй байдал, секц дугуйлангийн үйл ажиллагаа нь хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж байх.

Цогцолбор сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдийн эрхийн чиглэлээр

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нөхцөл байдалтай биечлэн танилцаж, багш ажилчдын санал хүсэлтийг сонсох ажил зохион байгуулах;
2. Дотуур байранд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрах, сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, гадна, дотно орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, хүүхэд хөгжлийн болон хичээл давтах өрөө, номын санд засвар үйлчилгээг хийх, шаардлагатай бол шинээр ашиглалтад оруулах, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэхэд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;
3. Сургуулийн дотуур байрыг их засвар оруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, засварын ажлын явц байдалд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллах;
4. Сургуулийн дотуур байрны үйл ажиллагаанд сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээнд тавигдах MNS6781:2019 стандартын хэрэгжилтийг хангуулах;
5. 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 498 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолыг баримтлан мөрдүүлж ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих;
6. Дотуур байрны багш, ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгох талаар холбогдох албан тушаалтанд чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах;


7. Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдын хувийн нууцтай холбоотой мэдээллийг Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нийцүүлэн хамгаалах зохицуулалтыг дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд Шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн талаар нотлох баримтын хамт мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд хийсэн хяналт шалгалтын баримтжуулалтыг хавсаргав.

Хавсралт 9 хуудастай.

ГИШҮҮН

A red rectangular official stamp of the Mongolian National Human Rights Commission is centered on the page. Overlaid on the stamp is a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to read 'B. ENKBOLOD'. The stamp contains Mongolian text, including 'МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСССЫН' (Mongolian National Human Rights Commission) and 'ГИШҮҮН' (Member).

Б.ЭНХБОЛД


**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭНД ХҮРТЭЭМЖТЭЙ ЭСЭХЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ХЯНАЛТЫН ХУУДАС**




ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА: ТАЙЛБАРТ ОРСОН БАЙГУУЛЛАГУУД



ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ОГНОО: 2022.10.07-2022.10.12




ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЛБАН ТУШААЛТАН: ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АХЛАХ ШИНЖЭЭЧ Э.БОЛОРТУЯА




Тайлбар: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Шүүх, Прокурорын газар, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн газар зэрэг иргэд олноор үйлчлүүлдэг 15 байгууллагыг сонгож, дүн шинжилгээ хийнэ.


№	Стандарт үзүүлэлт/ хэмжээ		Тогтоогдсон нөхцөл байдал	Зурган тайлбар
1	Тэргэнцэртэй хүний үндсэн бүсчлэл	1500	1.Дархан-Уул аймгийн ЗДТГ нь Байгууллагын ойр орчим 1500 мм талбайд тэргэнцэртэй хүний үндсэн бүсчлэл хэвийн байв. 2.Эрүүл мэндийн газрын үндсэн бүсчлэл хэвийн. 3.Онцгой байдлын газар үндсэн бүсчлэл хэвийн. 4.Цагдаагийн газар тэргэнцэртэй хүний бүсчлэл хэвийн. 5.Прокурорын байгууллага үндсэн бүсчлэл хэвийн. 6.Анхан шатны шүүхийн Тамгын газар хэвийн. 7.Давж заалдах шатны Шүүхийн Тамгын газар хэвийн. 8.ГБХЗХГ үндсэн бүсчлэл хэвийн. 9.Улсын Бүртгэлийн хэлтэс үндсэн бүсчлэл хэвийн. 10.Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар үндсэн бүсчлэл хэвийн. 11.Нийгмийн Даатгалын хэлтэс үндсэн бүсчлэл хэвийн.	




2	Барилга, өрөө тасалгааны орц болон хаалга	≥85 см	<ol style="list-style-type: none"> 1.Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын барилгын хаалганы орц нь 132 см буюу 2 тал нь онгойдог хаалга байна. 2.Эрүүл мэндийн газар 99 см. 3.Онцгой байдлын газар 82 см. 4.Цагдаагийн газар 120 см хажуу тал нь онгойдог. 5.Прокурорын байгууллага 89 см хажуу тал нь онгойдог. 6.Анхан шатны шүүхийн Тамгын газар 98 см хажуу хаалга онгойдог. 7.Давж заалдах шатны шүүхийн тамгын газар гадна хаалга 106 см, дотор хаалга 108 см хажуу хаалга онгойно. 8.Улсын Бүртгэлийн хэлтэс орох хаалга 60 см, төв хаалга 74.5 см. 9.Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар дотор хаалга 148 см, гадна хаалга 169 см хажуу хаалга онгойно. 10.Нийгмийн Даатгалын хэлтэс гадна хаалга 98 см, дотор хаалга 76 см хажуу хаалга нь онгойно. 	  
---	---	--------	---	--

				
3	Хаалганы босго	≤2,5 см	<ol style="list-style-type: none"> 1. Дархан-Уул аймгийн ЗДТГ 2.5 см. 2.Эрүүл мэндийн газар 3.5 см. 3.Онцгой байдлын газар 3.8 см. 4.Цагдаагийн газар 2.8 см. 5.Прокурорын байгууллага гадна хаалга-2.0 см, дотор 5.4 см. 6.Анхан шатны шүүхийн Тамгын газар 6 см. 7.Давж заалдах шатны шүүхийн тамгын газар дотор хаалга 2.2 см. 8.ГБХЗХГ 2.0 см. 9.Улсын Бүртгэлийн хэлтэс орох хаалга 7 см. 10.Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар дотор хаалга 2.0 см. 11.Нийгмийн Даатгалын хэлтэс гадна хаалга 2.9 см. 	

				
4	Налуу зам /пандус/	Өргөлтийн өндөр 80 см-ээс , налуугийн өнцөг ≤1:12-оос ихгүй	<ol style="list-style-type: none"> 1.Дархан-Уул аймгийн ЗДТГ 92 см. 2.Эрүүл мэндийн газар 99 см. 3.Онцгой байдлын газар 102 см. 4.Цагдаагийн газар 120 см. 5.Прокурорын байгууллага 85 см. 6.Анхан шатны шүүхийн Тамгын газар 93 см. 7.Давж заалдах шатны шүүхийн тамгын газар 80. 8.ГБХЗХГ 96 см. 9.Улсын Бүртгэлийн хэлтэс орох хаалга 7 см. 10.Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар дотор хаалга 82 см. 11.Нийгмийн Даатгалын хэлтэс гадна хаалга 96 см. 	 

				
5	Шат	<p>Өндөр 15 см Өргөн 30 см Бариул 90 см</p>	<p>1.Шатны өндөр 18 см Өргөн 32 см Бариул байхгүй байна. 2.Шатны өндөр 58 см Өргөн 126 см Бариул байхгүй байна. 3.Шатны өндөр 15 см Өргөн 35 см Бариул байхгүй байна. 4.Шатны өндөр 18 см Өргөн 38 см Бариул байхгүй 5.Шатны өндөр 19 см Өргөн 37 см Бариул байхгүй 6.Шатны өндөр 14 см Өргөн 39 см Бариул байхгүй байна. 7.Шатны өндөр 15 см Өргөн 37 см Бариул 95 8.Шатны өндөр 17 см Өргөн 35 см Бариул 88 см 9.Шатны өндөр 18 см Өргөн 30 см</p>	 

			<p>Бариул байхгүй байна. 10.Шатны өндөр 16 см Өргөн 34 см Бариул 79 см. 11.Шатны өндөр 15 см Өргөн 35 см Бариул 97 см.</p>	
6	Хонгил ба гарах зам /гарц/	90 см-150 см	<ol style="list-style-type: none"> 1. Дархан-Уул аймгийн ЗДТГ 98см. 2. Эрүүл мэндийн газар 96 3. Онцгой байдлын газар 86 см. 4. Цагдаагийн газар 102 см. 5. Прокурорын байгууллага 148 см. 6. Анхан шатны шүүхийн Тамгын газар 106 см. 7. Давж заалдах шатны шүүхийн тамгын газар дотор хаалга 92 см. 8. ГБХЗХГ 97 см. 9. Улсын Бүртгэлийн хэлтэс гарах хаалга 103 см. 10. Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар хаалга 99 см. 11. Нийгмийн Даатгалын хэлтэс гадна хаалга 99 см. 	
7	Ариун цэвэр, эрүүл ахуйн зориулалттай өрөө	-	Тайлбарт орсон 11 байгууллага эрүүл ахуйн зориулалттай өрөөгүй байв.	

8	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ	Багана, тулгуур хийц болон бусад зүйлсээс зайлж гарах тэмдэг, тэмдэглэгээтэй байх;	Тайлбарт орсон 11 байгууллагаас анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байхгүй 8, тэмдэг тэмдэглэлээтэй 3 байгууллага нь байв.	
9	Сонсголын бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцох;	Дүлий болон сул сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулж мэдээллийг зайлшгүй хүлээн авах шаардлагаар өрөө тасалгаа дуу авиа сонсогдох байдлаар	Тайлбарт орсон 11 байгууллагаас 9 байгууллага нь сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулж мэдээллийг хүлээн өгөх өрөө тасалгаа байхгүй дуу авиа байхгүй байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэст сонсголын бэрхшээлтэй иргэнд үйлчлэх цахим хэлмэрч орчуулагч ажиллаж байна.	
10	Хүлээлгийн сандалтай эсэх;		Дээрх 11 байгууллага бүгд хүлээлгийн сандалтай байв.	

11

Нийтийн бие засах
өрөө байгаа эсэх;

Тус 11 байгууллагаас Нийтийн бие
засах өрөө байгаа боловч хөгжлийн
бэрхшээлтэй иргэнд зориулсан бие
засах өрөөгүй 9 байгууллага байна.
Харин Хөдөлмөр халамж
үйлчилгээний газар, Нийгмийн
даатгалын хэлтэс нь хөгжлийн
бэрхшээлтэй иргэнд зориулсан
биез засах өрөөтэй байв.



Дүгнэлт:

Төрийн байгууллагуудын барилга байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй эсэхэд хяналтын хуудасны дагуу Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Прокурорын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн Даатгалын хэлтэс, Улсын Бүртгэлийн хэлтэс, Гэр бүл Хүүхэд залуучууд хөгжлийн газар, Онцгой байдлын газар, Анхан шатны Шүүхийн Тамгын газар, Давж Заалдах шатны шүүхийн тамгын газар нийт 11 байгууллагад дүн шинжилгээ хийхэд дээрх нөхцөл байдал тогтоогдож байна.

Дээрх төрийн захиргааны байгууллагуудын барилга байгууламжууд нь налуу зам байгаа боловч Монгол Улсын стандарт MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, Үндсэн шаардлагад нийцэхгүй байна. Түүнчлэн багана, тулгуур хийц болон бусад зүйлсээс зайлж гарах тэмдэг, тэмдэглэгээ байхгүй Монгол Улсын стандарт MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, Үндсэн шаардлагад нийцэхгүй байна. Тайлбарт орсон 11 байгууллагуудаас 9 байгууллага нь сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулж мэдээллийг хүлээн өгөх өрөө тасалгаа байхгүй, дуу авиа байхгүй байна.

Харин Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс нь сонсголын бэрхшээлтэй иргэнд үйлчлэх цахим хэлмэрч, орчуулагч үйлчилгээ нэвтрүүлж төрийн үйлчилгээг хүний эрхэд суурилсан хандлагаар хүртээмжтэй хүргэж байгаа нь сайшаалтай байна. Мөн Дархан-Уул аймгийн Нийгмийн Даатгалын хэлтэс нь 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдөр тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан төслийг хэрэгжүүлэн, ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор байгууллагынхаа гадна үүдээр орох налуу замыг засварлан ажилласан байна.

Цаашид Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Прокурорын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газар, Онцгой байдлын газар, Анхан шатны шүүхийн Тамгын газар, Давж заалдах шатны Шүүхийн Тамгын газар, төрийн байгууллагуудын барилга байгууламж нь Монгол Улсын стандарт MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, Үндсэн шаардлагад нийцсэн байхаар засаж сайжруулах ажлыг эрчимжүүлэхийг зөвлөж байна. /Дээр дурдсан зургуудыг түүвэрлэж оруулсан болно./

БОЛОВСУУЛСАН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Э. Болортуяа

Э.БОЛОРТУЯА